

## “САНСАР ДИЖИТАЛ” ХХК-ИЙН ОЛОН СУВАГ ДАМЖУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ НӨХЦӨЛ /RAO/

Телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч (ОСДҮЭ) “САНСАР ДИЖИТАЛ” ХХК -ийн хэрэглэгчдэд түгээх сүлжээнд холбогдоход дараах техникийн нөхцөлийг хангасан байх шаардлагыг тавина.

Энэхүү нөхцөлийг Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид “Зохицуулах хороо” гэх)-ны 2021 оны 33 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам” (цаашид “Холболтын журам” гэх)-ын 2.5 дах хэсэгт заасныг баримтлан боловсруулсан болно.

“САНСАР ДИЖИТАЛ” ХХК нь Телевиз, радиогийн олон суваг дамжуулах №23400037 тоот тусгай зөвшөөрлийн хүрээнд өөрийн DVB-T2 стандартаар “Мобайл ТВ” үйлчилгээгээ Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт хүргэдэг.

### 1. Сүлжээнд холбогдох технологийн стандарт, горим, нөхцөл шаардлага

Телевизийн студиас өгөх дохио нь дараах стандарт, үзүүлэлтийг хангана.

ИНТЕРФЕЙС	
Дүрсийн оролт	HD болон SD форматаар SMPTE 292M (HD-SDI) гэрээнд аль форматаар дамжуулж байгааг тусгах
Дууны оролт	Embedded audio (Дүрсний сигналд нь суулгасан аудио сигнал)
ДҮРСИЙН ҮЗҮҮЛЭЛТ	
Дүрсийн харьцаа	16:9
SD нягтрал	SD-SDI 625@50i
HD нягтрал	HD-SDI, 1080@50i шахалтын стандарт нь MPEG/AVC (H.264)
ДУУНЫ ҮЗҮҮЛЭЛТ	
Дууны түвшин	Монгол Улсын “Тоон телевизийн студи. 2-р хэсэг: Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага” MNS 5592-2:2016 стандартад заасны дагуу Олон улсын EBU R128 зөвлөмжийг мөрдөх
Дууны кодлол	Стерео болон MPEG layer 2

### 2. Зааглах цэгийн байршил, ашиглалт үйлчилгээ

2.1 Сүлжээнд холбогдох зааглах цэгийн боломжит байршлуудыг дараах хүснэгтэд харуулав.

Зааглах цэг байрлах хаяг (Боломжит зааглах цэгүүдийн байршил)	Зааглах цэг дэх холболтын тоног төхөөрөмжийн мэдээлэл (нэр, брэнд, үндсэн үзүүлэлт гм)	Тайлбар
Байршил 1: /Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, “Сансар кабель ХХК байр, “Эс Ти Би Эс” ХХК/	“Эс Ти Би Эс” ХХК-ийн Optic receiver, Optic transmitter	Зааглах цэгт өөрийн сигналыг хүргэхтэй холбоотой сүлжээний түрээс, татах, ашиглалт үйлчилгээг Телевизийн үйлчилгээ эрхлэгч хариуцна. /3 дагч этгээдээр гүйцэтгүүлж болох ба энэ тухайгаа ОСДҮЭ-д заавал мэдэгдэнэ/
Байршил 2: /ЧД, 3-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, “Сансар Дижитал” ХХК-ийн /HEADEND/ Зогсуур-1, Зогсуур-2	“Сансар Дижитал” ХХК –ийн Spliter	


2.2 Телевизийн үйлчилгээ эрхлэгч нь өөрийн студиас зааглах цэг хүртэлх сүлжээг (сүлжээ түрээслэх, татах, ашиглалт үйлчилгээ зэрэг) хариуцна.

2.3. Телевизийн үйлчилгээ эрхлэгч нь зааглах цэгийг дээр зааснаас өөр цэгт тогтоох саналтай бол хүсэлтийг албан бичигтээ тодорхой дурдаж, техникийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг ирүүлнэ. Хэрвээ тус зааглах цэг нь Зохицуулах хорооноос баталсан Холболтын журмын Хавсралт №4-д зааснаас өөр газарт байрлах бол албан бичгийн хувийг Зохицуулах хороонд илгээнэ.

2.4 Тоног төхөөрөмжийн мэдээлэл:

ОСДҮ-ний сүлжээнд холбогдоход нэмэлтээр шаардагдах тоног төхөөрөмжийн техникийн нөхцөл болон шаардлагуудыг хавсралт №2-т оруулав.

2.5 Холболтын схем, зураглал



### 3. Сүлжээнд холбогдох, гэрээ байгуулах үйл ажиллагааны нарийвчилсан мэдээлэл

- 3.1 Сүлжээнд холбогдох, гэрээ байгуулах хүсэлтийг аль нэг талдаа бичгээр гаргах бөгөөд хүсэлтийг ажлын 10 /арав/ хоногт багтаан хүсэлт гаргасан талд бичгээр мэдэгдэнэ.
- 3.2 Гэрээтэй холбоотой асуудлаар хэнтэй харилцах тухай “Хавсралт-4”-д дурдсан нөхцөлөөр харилцан шуурхай мэдээлэл солилцож, шуурхай шийдвэрлэнэ.

### 4. Сүлжээнд холбогдох төлбөр тооцооны мэдээлэл

- 4.1 Зохицуулах хорооноос баталсан Холболтын журмын 2.9-д заасны дагуу Харилцаа холбооны үйлчлэгч нь сүлжээнд холбогдох гэрээ байгуулах, төлбөрийн хэмжээг тогтоохдоо бизнесийн аливаа алдагдлыг нөхөх зорилго агуулахгүй, мөн журмын 8-р хэсгийг баримтална.
- 4.2 Талууд зааглах цэгээс 2 тийш өөрсдийн сүлжээ, ашиглалт үйлчилгээг хариуцах ба харилцан төлбөр төлөхгүй болно.

<p><b>Зааглах цэг байрлах хаяг</b> (Хэрвээ холболтын төлбөр нь зааглах цэгийн байршилаас хамаарах бол тус бүрд нь бичнэ)</p>	<p><b>Холболтын төлбөр</b> (тухайн ТВ-ийг өөрийн сүлжээнд холбоход гарах өртөгт суурилсан зардал байх ба орон нутаг болон Улаанбаатар хотын хувьд тус тусад нь гаргана.)</p>	<p><b>Үндэслэлт, тайлбар</b></p>
--	--	----------------------------------

<p>Байршил 1: Байршил нь Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2р хороо, “Сансар кабель ХХК байр, “Эс Ти Би Эс” ХХК-ийн Optic receiver, Optic transmitter</p>	<p>Гэрээний 7.1-д заасны дагуу талууд зааглах цэгээс 2 тийш өөрсдийн сүлжээ, ашиглалт үйлчилгээг хариуцах ба харилцан төлбөр төлөхгүй болно.</p>	<p>Зааглах цэгээр дамжуулан хүлээн авч байгаа тул шаардлагагүй</p>
<p>Байршил 2: ДАМЖУУЛАГЧ БУЮУ ОСДҮЭ /ЧД, 3-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, “Сансар Дижитал” ХХК- ийн /HEADEND/ Зогсуур-1, Зогсуур-2</p>	<p>Гэрээний 7.1-д заасны дагуу талууд зааглах цэгээс 2 тийш өөрсдийн сүлжээ, ашиглалт үйлчилгээг хариуцах ба харилцан төлбөр төлөхгүй болно.</p>	

**БАТЛАВ.**

“САНСАР ДИЖИТАЛ” ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ:

...../...../

**БАТЛАВ.**

“.....” ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ:

...../...../

\_\_\_\_\_, **БОЛОН** \_\_\_\_\_-ИЙН  
**ХОЛБОЛТ, ДАМЖУУЛЛЫН ГЭРЭЭ**

20... оны ..... сарын .....-ны өдөр

№ .....

Улаанбаатар хот

Холболт, дамжууллын энэхүү гэрээ нь Дэлхийн Худалдааны Байгууллагаас гаргасан Зохицуулалтын зарчмууд (Regulatory Principles Reference Paper /RPRP/), Харилцаа холбооны тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Харилцаа Холбооны Зохицуулах хороо (цаашид “ХХЗХ” гэх)-ноос батлагдан гарсан харилцан холболт, холболтын талаархи холбогдох журмууд болон тус тусын байгууллагын дүрэмд үндэслэсэн болно.

Энэхүү Холболт, дамжууллын гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г:

**Нэг талаас:** Улсын бүртгэлийн 9011212099, регистрийн 2885654 дугаартай “САНСАР ДИЖИТАЛ” ХХК (цаашид “Дамжуулагч тал” гэх), түүнийг төлөөлж ..... албан тушаалтай ..... овогтой .....,

**Нөгөө талаас:** “.....” (цаашид “Телевиз” гэх), түүнийг төлөөлж ..... албан тушаалтай ..... овогтой ....., нар (хамтад нь “Талууд”, зарим тохиолдолд дангаар нь “Тал” гэх) доорхи нөхцөлийг хэлэлцэн тохиролцож, харилцан зөвшөөрснөөр энэхүү гэрээг байгуулав.

**Нэг.Ерөнхий зүйл**

- 1.1 Нэг талаас Дамжуулагч нь Дамжуулагч нь Телевизийн бэлтгэсэн “.....” телевизийн нэвтрүүлгийг бүрэн хэмжээгээр, HD/SD форматаар хүлээн авч, DVB-T2 стандартаар “Мобайл ТВ” үйлчилгээгээ Улаанбаатар хот болон хотын алслагдсан дүүргийн айл өрх, албан байгууллагад чанарын өндөр түвшинд хэрэглэгчдэд хүргэх зорилгоор Телевиз нь Дамжуулагчийн сүлжээнд холболт хийх болон хөтөлбөрийг дамжуулах хэлцлийн нөхцөл, түүнтэй холбоотой асуудлыг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.
- 1.1. Гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш “Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”-д заасны дагуу 10 хоногийн дотор Талууд хавсралтуудын хамт гэрээг ХХЗХ-д хүргүүлж, бүртгүүлнэ.
- 1.2. Талууд холболт, дамжуулал хийхдээ ямар нэгэн ялгаваргүй буюу ижил нөхцөлөөр хандах, ил тод, харилцан ашигтай байх, өрсөлдөөний эсрэг шударга бус аливаа үйлдэл гаргахгүй байх зарчмуудыг баримтална.
- 1.3. Энэхүү гэрээ нь гэрээний ерөнхий нөхцөл болон дараах хавсралт хэсгүүдээс бүрдэнэ.
  - 1.3.1. Хамрах хүрээ /Хавсралт 1/
  - 1.3.2. Холболт хийх техникийн үзүүлэлт /Хавсралт 2/
  - 1.3.3. Зааглах цэгийн байршил, зураглал /Хавсралт 3/

- 1.3.4. Харилцан мэдээлэл солилцох албан тушаалтан /Хавсралт 4/
  - 1.3.5. Төлбөрийн мэдээлэл /Хавсралт 5/
  - 1.3.6. Телевизийн хөтөлбөр ирүүлэх формат /Хавсралт 6/
- 1.4. Энэ зүйлийн 1.3 дэх хэсгийн 1.3.1-1.3.6-д заасан хавсралтууд нь энэ гэрээний салшгүй хэсэг болно.

### **Хоёр.Дамжуулагчийн эрх, үүрэг**

- 2.1. Дамжуулагч тал нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:
- 2.1.1. Нөгөө талаас хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхийг шаардах;
  - 2.1.2. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, цуцлах тухай санал гаргах;
  - 2.1.3. Нөгөө тал энэхүү гэрээнд заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд хариуцлага тооцож, учирсан хохирлоо нөхөн төлүүлэх;
  - 2.1.4. Нөгөө тал гэрээний үүргээ биелүүлээгүй, эсхүл эрх бүхий байгууллагаас шаардсан бол холболтыг салгах, хязгаарлалт хийх;
  - 2.1.5. энэ гэрээ болон хуульд заасан бусад эрх.
- 2.2. Дамжуулагч нь дараах үүрэг хүлээнэ:
- 2.2.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх;
  - 2.2.2. Өөрийн сүлжээнд холбогдох болон харилцан холболт хийх боломжийг бүрдүүлэх;
  - 2.2.3. Телевизийн хөтөлбөрийг, зааглах цэгээр дамжуулан, техникийн шаардлага хангасан шилэн кабелиар, Дамжуулагчийн Улаанбаатар хот, ЧД, 3-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, “Сансар Дижитал” ХХК-ийн байр /HEADEND/ дээр хүлээн авч, DVB-T2 стандартаар “Мобайл ТВ” үйлчилгээний хэрэглэгчдэд MNS 5592-2:2016 стандартын шаардлагын дагуу нийлүүлэгчийн ирүүлсэн сингалын түвшинг бууруулахгүйгээр дамжуулах үүрэгтэй.
  - 2.2.4. өөрийн сүлжээний найдвартай байдлыг хангаж, гадны халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллах;
  - 2.2.5. Дамжуулагч нь зааглах цэг дэх өөрийн өмчлөлд хамаарах тоног төхөөрөмж, түүний ашиглалт үйлчилгээг өөрөө хариуцах бөгөөд найдвартай, аваар осолгүй, ашиглалтын болон технологийн горимыг телевиз талаас хамааралгүй зохион байгуулж ажиллах үүрэгтэй.
  - 2.2.6. Дамжуулагч нь Телевизийн ирүүлсэн хөтөлбөрт өөрчлөлт оруулах эрхгүй ба зөрүүлснээс үүдсэн хариуцлагыг хүлээнэ.
  - 2.2.7. Дамжуулах төхөөрөмжинд гэмтэл гарсан, телевиз тал байршлаа өөрчилсөн, зааглах цэгийн байршил өөрчилсөн зэрэг шалтгааны улмаас холболтыг салгах, хязгаарлалт хийх тохиолдолд Зохицуулах хороо болон нөгөө талдаа 72 цагийн өмнө үндэслэлийн хамт, дамжуулагч талын сүлжээний хэрэглэгчдэд 48 цагийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.
  - 2.2.8. Дамжуулагч нь Нийлүүлэгч талын бэлтгэн цацаж байгаа нэвтрүүлэг контент нь Монгол улсын хууль дүрэм, хориглосон үйл ажиллагааг зөрчсөн эсэх талаар ямар нэгэн хариуцлага хүлээхгүй ба хөтөлбөр дундуур аливаа хэлбэрийн зар, сурталчилгаа дамжуулахыг хориглоно.
  - 2.2.9. Өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас нөгөө тал болон гуравдагч этгээдэд учруулсан хохирлыг нөхөн төлөх;
  - 2.2.10. Энэ гэрээ болон хуульд заасан бусад үүрэг.

### **Гурав.Телевизийн эрх, үүрэг**

- 3.1. Телевиз нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- 3.1.1. Нөгөө талаас хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхийг шаардах;
  - 3.1.2. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, цуцлах тухай санал гаргах;
  - 3.1.3. Нөгөө тал энэхүү гэрээнд заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд хариуцлага тооцож, учирсан хохирлоо нөхөн төлүүлэх;
  - 3.1.4. Дамжуулагч талын сүлжээгээр дамжин хэрэглэгчдэд очиж байгаа өөрийн бүтээгдэхүүний чанар, стандартад хяналт тавих эрхтэй.
  - 3.1.5. Энэ гэрээ болон хуульд заасан бусад эрх.
- 3.2. Телевиз дараах үүрэг хүлээнэ:
- 3.2.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх;
  - 3.2.2. Телевиз тал нь Дамжуулагч талын сүлжээний холболтод хавсралт №2 дэх шаардлага болон MNS 5592-2:2016 стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг гэрээний 5.2.1-т заагдсан, зааглах цэгээр дамжуулан шилэн кабелиар Дамжуулагч талд тасралтгүй нийлүүлэх үүрэгтэй.
  - 3.2.3. Телевиз нь зааглах цэг дэх өөрийн өмчлөлд хамаарах тоног төхөөрөмж, түүний ашиглалт үйлчилгээг өөрөө хариуцах бөгөөд найдвартай, аваар осолгүй, ашиглалтын болон технологийн горимыг Дамжуулагч талаас хамааралгүй зохион байгуулж ажиллах үүргийг дангаар хүлээнэ.
  - 3.2.4. Өөрийн нэвтрүүлгээ MNS 5592-2:2016 стандартын шаардлага хангахуйц түвшинд дамжуулж эфирийн сахилгыг сахиж, мэдээ, мэдээлэл, нэвтрүүлгийн эх сурвалжийн үнэн бодит байдалд хяналт тавьж, эрх зүйн асуудлаа дангаараа бүрэн хариуцах үүрэгтэй.
  - 3.2.5. Телевиз нь өөрийн нэвтрүүлгийн хөтөлбөрийг үг үсгийн алдаагүй, хавсралт №6 дахь форматаар, Лхагва гараг бүр Дамжуулагчийн info@sansardigital.mn и-мэйл хаяг руу урьдчилан илгээж, хөтөлбөрийн цагийг баримтлах үүрэгтэй.
  - 3.2.6. Энэ гэрээний “Хавсралт №4”-д заасан албан тушаалтан өөрчлөгдсөн тухай бүрт шинэчилсэн мэдээллийг даруй явуулж байх;
  - 3.2.7. Зааглах цэг хүртэлх сүлжээг гуравдагч этгээдээс түрээслэх бол холболт хийхдээ Дамжуулагч талд заавал мэдэгдэх, мөн тухайн түрээслүүлэгчийн болон эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд шуурхай холбогдох албан тушаалтны мэдээлэл зэргийг Дамжуулагчид гаргаж өгөх;
  - 3.2.8. Зааглах цэг хүртэлх сүлжээг гуравдагч этгээдээс түрээслэж байгаа тохиолдолд түрээслүүлэгчийн шугам, сүлжээ, тоног төхөөрөмжийн ашиглалт үйлчилгээ, холболт, дамжуулалт, хэвийн найдвартай ажиллагаанд байнга хяналт тавьж Дамжуулагчийн өмнө хариуцах;
  - 3.2.9. зааглах цэгээс гарсан сүлжээг бусад дамжуулагч руу дамжуулахаар бол Дамжуулагч талд мэдэгдэх;
  - 3.2.10. Гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх;
  - 3.2.11. Өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас нөгөө тал болон гуравдагч этгээдэд учруулсан хохирлыг нөхөн төлөх;
  - 3.2.12. Энэ гэрээ болон хуульд заасан бусад үүрэг.

#### **Дөрөв.Гэрээний хугацаа**

- 4.1. Талуудын эрх бүхий төлөөлөгчид энэхүү гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулсан /тамга дарсан/ өдрөөс эхлэн 1 жилийн хугацаанд хүчин төгөлдөр болно.
- 4.2. Гэрээний хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө талууд гэрээг цуцлах санал гаргаагүй тохиолдолд гэрээг дахин нэг жилийн хугацаатай сунгагдсанд тооцно.
- 4.3. Гэрээний хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа дараагийн гэрээ батлагдсан өдрөөр дуусгавар болно.

## **Тав. Техникийн нөхцөл, зааглах цэг**

### 5.1. Холболт хийх техникийн нөхцөл:

- 5.1.1. Холболтыг Талуудын эрх бүхий техникийн инженерүүд хамтран хийнэ.
- 5.1.2. Талууд гэрээ байгуулсанаас хойш ажлын 10 хоногийн дотор холболтыг хийж, хэвийн ажиллагааг эхлүүлнэ.
- 5.1.3. Холболт хийхэд шаардагдах техник төхөөрөмж, түүнд тавигдах шаардлага, стандарт үзүүлэлт зэрэг нь энэ гэрээний “Хавсралт №2”-т заасны дагуу байна. Энэ гэрээний “Хавсралт №2”-т орсон өөрчлөлтийг тухай бүр тусгаж байна.
- 5.1.4. Телевизийн студиас ирэх дохио нь Монгол Улсын “Тоон телевизийн студи. 2 дугаар хэсэг: Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага” MNS 5592-2:2016 стандарт болон Олон улсын стандарт, зөвлөмжүүдийг хангасан байна.
- 5.1.5. Талуудын сүлжээ хооронд холболт хийх дамжуулах шугам нь ..... (өндөр хурдны шилэн кабелийн сүлжээ) ..... байна.

### 5.2. Зааглах цэг:

- 5.2.1. Зааглах цэг нь Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, “Сансар КаТВ” байранд байрлах “ЭС ТИ БИ ЭС” ХХК-ийн өмчлөлийн Optic receiver, Optic transmitter бүхий Холболтын төв /“Хавсралт №3”-т үзүүлэв/ байна. Зааглах цэг хүртэлх харилцан холболтыг Телевиз, Зааглах цэгээс HEADEND хүртэлх харилцан холболтыг Дамжуулагч тал хариуцна.
- 5.2.2. Талууд зааглах цэгээс 2 тийш шугамыг таслан хэмжилт, шалгалт хийх техникийн боломж, нөхцөлийг хангасан байна.

### 5.3. Хамрах хүрээ:

- 5.3.1. Телевиз нь Дамжуулагчийн тусгай зөвшөөрлийн хамрах хүрээнд телевизийн хөтөлбөрийг хүргэх тусгай зөвшөөрөлтэй байна.

## **Зургаа. Ашиглалт үйлчилгээ**

- 6.1. Талууд зааглах цэгээс 2 тийш өөрсдийн шугам, төхөөрөмжийн ашиглалт үйлчилгээ буюу бүрэн бүтэн байдал, тасалдалгүй найдвартай ажиллагаа, чанарын хяналт, гэмтэл засварыг хариуцна.
- 6.2. Телевиз нь зааглах цэг хүртэл түрээсийн шугам ашиглаж байгаа бол тухайн шугам, сүлжээний ашиглалт үйлчилгээ, найдвартай ажиллагаа, эвдрэл гэмтэл, үүнтэй холбогдон үүсэх бусад асуудлыг Дамжуулагч талын өмнө хариуцаж ажиллана.
- 6.3. Телевиз нь зааглах цэг хүртэлх сүлжээг гуравдагч этгээдээс түрээслэх тохиолдолд Дамжуулагч талтай харилцан тохиролцож, холболт хийхдээ заавал мэдэгдэн, эвдрэл гэмтэл гарсан үед яаралтай холбогдох хариуцсан ажилтны мэдээллийг энэ гэрээний “Хавсралт 4”-д заасны дагуу Дамжуулагчид гарган өгч байна.
- 6.4. Телевиз нь зааглах цэгээс гарсан сүлжээг бусад дамжуулагч руу дамжуулахаар бол Дамжуулагч талд мэдэгдэнэ.
- 6.5. Талууд өөрийн сүлжээнд энэхүү гэрээгээр зохицуулж байгаа холболтод хамаарах аливаа туршилт, техникийн шинэчлэл, урьдчилан сэргийлэх хэмжилт, шалгалт хийх тохиолдолд ажиллах хугацаа, горимыг ажлын 5 хоногийн өмнө урьдчилан тохиролцож, мөрдөн ажиллана.
- 6.6. Аль нэг тал нь нөгөө талынхаа үйлчилгээг тасалдуулахгүй байх үүргийг хүлээх ба хэрэв гэмтэл саатал гарвал хариуцсан тал нь 24 цагийн дотор шуурхай арга хэмжээ авч, гэмтлийг засварлан нөгөө талдаа нэн даруй мэдэгдэх ба нөөц суваг, тоног төхөөрөмжид шилжүүлнэ. Энэхүү гэмтэл саатал, авсан арга хэмжээний талаар Талуудын техникийн ажилтнууд тодорхой гэмдэглэл хөтөлж, удирдлагаар баталгаажуулна.

- 6.7. Аль нэг талын буруутай үйлдлээс шалтгаалан үйлчилгээ саатах, тасрах тохиолдолд буруутай этгээд нь нөгөө тал болон хэрэглэгчийг хохироохгүй байх бүхий л арга хэмжээ /хохирлыг нөхөн төлүүлэх гэх мэт/-г авна.
- 6.8. Техникийн гэмтэл, саатал, үзлэг үйлчилгээ, талуудын байршил өөрчлөгдөх, нүүж шилжих үеийн түр салгалтын үед Дамжуулагч тал нь Телевизийн сувгаар дараах мэдэгдэл бүхий текстийг дамжуулна:
  - 6.8.1. Дамжуулагч талд техникийн гэмтэл, саатал гарсан бол “ДАМЖУУЛАГЧИЙН СҮЛЖЭЭНД ГЭМТЭЛ ГАРСАН ТУЛ ХҮЛЦЭЛ ӨЧЬЕ”;
  - 6.8.2. Телевизийн талд гэмтэл, саатал гарсан бол “ТЕЛЕВИЗЭД ТЕХНИКИЙН ГЭМТЭЛ ГАРСАН ТУЛ ХҮЛЦЭЛ ӨЧЬЕ”;
  - 6.8.3. хуваарьт үзлэг, үйлчилгээ хийж байгаа бол “ТЕХНИКИЙН ҮЗЛЭГ ХИЙЖ БАЙНА.” боломжтой бол хэвийн үргэлжлэх хугацааг дурдах.
- 6.9. Талууд ашиглалт үйлчилгээг хэвийн байлгах талаар харилцан мэдээлэл солилцох албан тушаалтан, хаяг, холбоо барих хэрэгсэл зэргийг энэ гэрээний “Хавсралт 4”-д заасан байна.
- 6.10. ОСДҮЭ-н сүлжээгээр дамжиж байгаа телевизийн бусад суваг нэмэгдэж, хасагдах, үйлчилгээний багцад шинэчлэлт өөрчлөлт оруулж буй тохиолдолд телевизийн үйлчилгээ эрхлэгч нарт урьдчилан мэдэгдэж, сувгийн дугаарлалтыг зөвхөн харилцан тохиролцсоны үндсэн дээр өөрчлөх, бусад үед гэрээнд заасан дугаарлалтыг баримтлан ажиллана.
- 6.11. Телевизийн буруутай үйлдлээс шалтгаалж гэрээг түдгэлзүүлсэн, цуцалснаас үүдэн бусад сувгийн дугаарлалтад өөрчлөлт орохгүй ба тухайн сувгийн дугаарлалтыг дамжуулагчийн зүгээс бусад нийлүүлэгчид санал болгож болно.

#### **Долоо.Төлбөр тооцоо**

- 7.1. Талууд зааглах цэгээс 2 тийш өөрсдийн сүлжээ, ашиглалт үйлчилгээг хариуцах ба харилцан төлбөр төлөхгүй болно.
- 7.2. Телевиз/Дамжуулагч нь энэхүү гэрээний “Хавсралт 5”-д заасан төлбөрийг гэрээ байгуулснаас хойш ажлын 14 хоногийн дотор Дамжуулагчийн ..... банкны ..... тоот дансанд шилжүүлнэ.
- 7.3. Энэ гэрээний “Хавсралт 5”-д заасан төлбөрийн ..... хувийг энэ гэрээний “Хавсралт .....”-д заасан бартерын зарчмаар барагдуулж болно.
- 7.4. Телевиз/ Дамжуулагч гэрээгээр тохирсон хугацаанд төлбөрөө төлөөгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд “Хавсралт 5”-д заасан төлбөрийн дүнгийн 0.3 хувиар тооцож нөгөө талдаа алданги төлнө.
- 7.5. Талуудын санхүүгийн албаны холбогдох ажилтнууд нь төлбөрийн тооцоог сар бүр нийлнэ. Холбогдох ажилтны мэдээллийг энэ гэрээний “Хавсралт 4”-д заасан. Ажил хариуцсан хүмүүсийн ажлын зохион байгуулалт, техникийн саатал нь тооцоо хийх хугацааг хойшлуулах үндэслэл болохгүй.
- 7.6. Дамжуулагч нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой реклам, зар сурталчилгаа, нэвтрүүлгийг телевизээр харилцан тохиролцсоны үндсэн дээр үнэ төлбөргүй дамжуулж болно.

#### **Найм.Харилцан мэдээлэл солилцох**

- 8.1. Телевиз нь долоо хоног бүрийн Лхагва гаригийн 15:00 цагаас өмнө өөрийн албан ёсны и-мэйл хаягаас Дамжуулагч талын [info@sansardigital.mn](mailto:info@sansardigital.mn) и-мэйл хаяг руу телевизийн хөтөлбөрийг илгээж, хөтөлбөрийн цагийг баримтална. Телевизийн хөтөлбөр нь энэ гэрээний “Хавсралт 6”-д заасан форматын дагуу, үг үсгийн алдаагүй байна.
- 8.2. Телевиз хөтөлбөрт өөрчлөлт оруулах бол энэ зүйлийн 8.1-д заасан цахим хаягаар дамжуулагчид 6 цагийн өмнө урьдчилан мэдэгдэж, өөрчлөлтийг оруулна.



- 8.3. Дамжуулагч талд мэдэгдэлгүй хөтөлбөрт оруулсан өөрчлөлт, хөтөлбөрийг зөрүүлснээс үүссэн аливаа гомдол, маргаантай асуудлыг Дамжуулагч тал хариуцахгүй.
- 8.4. Энэхүү гэрээний хүрээнд Талууд харилцан мэдээлэл солилцоход дараах зарчим, дарааллыг баримтална. Үүнд:
- 8.4.1. Энэхүү гэрээний 6 дугаар зүйлийн 6.8-д зааснаас бусад тохиолдолд энэхүү гэрээтэй холбоотой харилцааг талууд албан бичгээр, эсхүл и-мэйлээр баталгаажуулна.
  - 8.4.2. Нэг талын бичгээр гаргасан хүсэлтэд нөгөө тал ажлын 5 хоногийн дотор бичгээр хариу өгнө.
  - 8.4.3. Мэдээлэл солилцоход холбогдох чиглэл бүрийн ажилтны мэдээллийг “Хавсралт 4”-д заана.
  - 8.4.4. Аль нэг талын нууц гэж үзсэн мэдээллийн нууцыг нөгөө тал хадгалах үүрэгтэй ба мэдээллийг өрсөлдөөний эсрэг ашиглахгүй.

### **Ес.Холболтыг салгах, хязгаарлалт хийх**

- 9.1. Талууд дор дурьдсан тохиолдлоос бусад ямар ч тохиолдолд холболтыг салгах, хязгаарлалт хийхгүй байна. Үүнд:
- 9.1.1. давагдашгүй хүчин зүйлс;
  - 9.1.2. гэрээнд оролцогч тал харилцан холболтын төлбөрөө төлөөгүй гэрээнд тохиролцсон боломжит хугацаанаас 3 сараар хэтрүүлсэн;
  - 9.1.3. техникийн гэмтэл саатал гарсан, эсвэл засвар, үзлэг шалгалт хийхээр харилцан тохиролцсон;
  - 9.1.4. эрх бүхий байгууллагаас хуульд заасан үндэслэл бүхий мэдэгдэл ирүүлсэн.
- 9.2. Энэ зүйлийн 9.1 дэх хэсгийн 9.1.2-д заасны дагуу гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас холболтыг салгах, хязгаарлалт хийх бол нөгөө тал болон Зохицуулах хороонд 72 цагийн өмнө үндэслэлийн хамт, Дамжуулагч талын сүлжээний хэрэглэгчдэд 48 цагийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.

### **Арав.Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл**

- 10.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлс /гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, сүлжээний хэт ачаалал, гуравдагч этгээдийн буруугаас сүлжээний үйлчилгээ тасалдах, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаан/-ийн улмаас Талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа ажлын 3 хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.
- 10.2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэдгийг Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас гэрчилсэн тохиолдолд давагдашгүй хүчин зүйл гэж үзэх бөгөөд уг хүчин зүйлд өртсөн тал нотлох үүрэг хүлээнэ.
- 10.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл Талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 10.4. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талууд гэрээний үүргээ биелүүлээгүй, эсвэл зохих ёсоор биелүүлээгүй бол хариуцлага хүлээхгүй болно.

### **Арван нэг.Гэрээ цуцлах болон гэрээ дуусгавар болох**

- 11.1. Дараах үндэслэлээр гэрээг цуцалж, дуусгавар болгоно. Үүнд:
  - 11.1.1. талууд харилцан тохиролцсон;
  - 11.1.2. Телевиз талын нэвтрүүлгийн бодлого гэрээ байгуулж байх үеийнхээс өөрчлөгдсөнийг ХХЗХ-ноос үл зөвшөөрсөн, Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг эрх бүхий байгууллага сунгахаас татгалзсан;
  - 11.1.3. Дамжуулагч талд ХХЗХ-ноос “Суваг дамжуулахыг хориглосон мэдэгдэл” ирсэн нөхцөлд Телевизийн саналыг үл харгалзан;
  - 11.1.4. Аль нэг тал нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, эсхүл удаа дараа биелүүлэхгүй байх.
- 11.2. Нэг талын хүндэтгэн үзэх шалтгааны улмаас гэрээ цуцлах тохиолдолд гэрээ цуцлах тухай мэдэгдлээ хуанлийн 30-аас доошгүй хоногийн өмнө албан бичгээр нөгөө талдаа мэдэгдэх ба нөгөө тал зөвшөөрснөөр гэрээг дуусгавар болсонд тооцно.
- 11.3. Аль нэг тал нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй байх, эсхүл удаа дараа биелүүлэхгүй байх тохиолдолд нөгөө тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх тухай шаардлагыг хүргүүлэх бөгөөд шаардлага хүргүүлснээс хойш ажлын 10 хоногийн дотор гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол нөгөө тал нь энэхүү гэрээний 12 дугаар зүйлийн 12.3-т заасны дагуу үүргийн гүйцэтгэлийг хангах аргыг хэрэглэх эрхтэй.
- 11.4. Энэхүү зүйлийн 11.3 дахь хэсэгт заасны дагуу үүргийн гүйцэтгэлийг хангах аргыг хэрэглэж эхэлснээс хойш 14 хоногийн дотор гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөгөө тал нэг талын санаачлагаар гэрээ цуцлах тухай мэдэгдлийг нөгөө талдаа хүргүүлж, нэг талын санаачилгаар гэрээг цуцална.

#### **Арав нэг.Хариуцлага**

- 12.1. Аль нэг тал нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй байх, эсхүл зөрчсөн тохиолдолд энэхүү гэрээ болон Монгол Улсын холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.
- 12.2. Аль нэг тал нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, аль нэг талын буруутай үйл ажиллагааны улмаас үйлчилгээ саатах, тасрах тохиолдолд буруутай этгээд нөгөө тал болон хэрэглэгчдэд учруулсан хохирлыг нөхөн төлнө.
- 12.3. Телевиз нь гэрээгээр тохирсон хугацаанд төлбөрөө төлөөгүй, эсхүл энэ гэрээнд заасан бусад үүргээ биелүүлэхгүй байх тохиолдолд Дамжуулагч талын шаардсан үүрэг гүйцэтгэвэл зохих хугацаанаас хугацаа хэтэрсэн хоног тутамд “Хавсралт 5”-д заасан төлбөрийн дүнгийн 0.5 хувиар тооцож нөгөө талд алданги төлнө.
- 12.4. Дамжуулагч нь энэ гэрээнд заасан үүргээ биелүүлэхгүй байх тохиолдолд Телевизийн шаардсан үүрэг гүйцэтгэвэл зохих хугацаанаас хугацаа хэтэрсэн хоног тутамд “Хавсралт 5”-д заасан төлбөрийн дүнгийн 0.5 хувиар тооцож нөгөө талд алданги төлнө.
- 12.5. Талууд энэ зүйлийн 12.3, 12.4-т заасан хариуцлага хүлээсэн нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх хууль зүйн үндэслэл болохгүй.
- 12.6. Дамжуулагч тал нь Телевизийн бэлтгэн цацаж байгаа нэвтрүүлэг, контент нь Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм журам, хориглосон хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

#### **Арван гурав.Маргаан шийдвэрлэх**

- 13.1. Энэ гэрээтэй холбогдон үүсч болох аливаа маргаан, санал зөрөлдөөнийг Талууд зөвшилцлийн журмаар шийдвэрлэхийг оролдох бөгөөд зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд маргаан, санал зөрөлдөөнийг ХХЗХ-нд хандаж шийдвэрлүүлнэ.
- 13.2. Зохицуулах хорооноос гаргасан шийдвэрийг маргалдагч Талууд аль болох хүлээж авах бөгөөд хэрэв ХХЗХ-ны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол Талууд Монгол Улсын шүүхэд хандах эрхтэй.

#### **Арван дөрөв.Бусад зүйл**

- 14.1. Энэхүү гэрээнд Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд эх хувьд засварласан буюу бусад аргаар оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлтийг хүчингүйд тооцно.
- 14.2. Гэрээнд орсон нэмэлт, өөрчлөлт бүрийг ХХЗХ-нд тухай бүр хүргүүлж, бүртгүүлж байна.
- 14.3. Энэхүү гэрээгээр зохицуулаагүй аливаа бусад асуудлыг Монгол Улсын дагаж мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.
- 14.4. Талуудын Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал, өмчлөгч, эзэмшигч өөрчлөгдсөн эсэхээс үл хамааран энэхүү гэрээний 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 14.5. Энэхүү гэрээ нь Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 14.6. Энэ гэрээ хүчин төгөлдөр болсноор Талуудын хооронд 20... оны ..... дугаар сарын .....-ний өдөр байгуулсан “.....” холболт, дамжууллын гэрээг цуцлагдсанд тооцох ба дээрх гэрээг цуцалсан нь уг гэрээний төлбөрийн шаардлага гаргах эрхийг хөндөхгүй буюу дуусгавар болгохгүй, тухайн шинэ гэрээ байгуулах хүртэлх хугацааны төлбөрийг тооцон бүрэн төлж барагдуулна.
- 14.7. Талуудын эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн хуулбар болон Гэрээний хавсралт, талуудын баталгаажуулсан нэмэлт өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

#### **ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**“САНСАР ДИЖИТАЛ” ХХК,түүнийг  
төлөөлж Техникийн захирал:**

..... /Б.АМГАЛАНБАТ/  
(Гарын үсэг, тамга)

Хаяг: Монгол улс, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, Сансар Дижитал ХХК-ийн байр  
Бүртгэлийн гэрчилгээ: 9011212099  
Регистрийн дугаар: 2885654  
Утас: 70001014, 99076818  
Электрон хаяг: [web.sansardigital.mn](http://web.sansardigital.mn)  
И-мэйл хаяг: [info@sansardigital.mn](mailto:info@sansardigital.mn)

**Гэрээ хариуцсан мэргэжилтэн:**

...../ Э.ОДОНЧИМЭГ /  
(Гарын үсэг)

Утас: 99901351

“.....” ХХК,  
түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал:

...../  
(Гарын үсэг, тамга)

Хаяг: .....

.....  
.....  
.....

И-мэйл хаяг: .....

Бүртгэлийн гэрчилгээ: .....

Регистрийн дугаар: .....

Утас: ....., Факс: .....

20... оны ..... сарын .....-ны өдрийн ..... тоот  
\_\_\_\_\_, \_\_\_\_\_-ын Холболт,  
Дамжууллын гэрээний Хавсралт 1

### ХАМРАХ ХҮРЭЭ

№	Хамрах хүрээ	Зөвшөөрөлтэй эсэх
<b>Дамжуулагч тал</b>		
1.	Улаанбаатар хот	Тийм
2.	Налайх дүүрэг	Тийм
3.	Багануур дүүрэг	Тийм
4.	Төв аймаг	Тийм
<b>Телевиз тал</b>		
1.	Улаанбаатар хот	
2.	Налайх дүүрэг	
3.	Багануур дүүрэг	
4.	Төв аймаг	

### ХАВСРАЛТ БАТАЛСАН:

“САНСАР ДИЖИТАЛ” ХХК,  
түүнийг төлөөлж техникийн захирал:  
..... /Б.АМГАЛАНБАТ/  
(Гарын үсэг, тамга)

түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал:  
..... /...../  
(Гарын үсэг, тамга)

“.....” ХХК,

20... оны ..... сарын .....-ны өдрийн ..... тоот  
 \_\_\_\_\_, \_\_\_\_\_-ын Холболт,  
 Дамжууллын гэрээний Хавсралт 2

## ХОЛБОЛТ ХИЙХ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### Холболт хийх техникийн нөхцөл:

- Холболт хийхэд шаардагдах техник төхөөрөмж, түүнд тавигдах шаардлага, стандарт үзүүлэлт зэрэг нь доор хүснэгтийн дагуу байх бөгөөд аливаа өөрчлөлтийг тухай бүрд тусгаж байна.
- Телевизийн студиэс ирэх дохио нь Монгол Улсын “Тоон телевизийн студи. 2-р хэсэг: Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага” MNS 5592-2:2016 стандарт болон олон улсын стандарт, зөвлөмжүүдийг хангасан байна.
- Талуудын сүлжээ хооронд холболт хийх дамжуулах шугам нь .....(өндөр хурдны шилэн кабелийн сүлжээ)..... байна.

Тоног төхөөрөмжийн стандарт болон шаардлагууд	
Баталгаажуулалт	Дамжуулагч болон хүлээн авагч нь ХХЗХ-ноос баталгаажуулалт хийгдсэн байх
Тохиргооны горим	HD-SDI/SDI/ASI signal auto recognition, not need select by hand
Стандарт	Дараах стандартуудтай нийцсэн байх SMPTE292M, SMPTE259M, SMPTE297M, SMPTE310M, SMPTE305M, DVB-ASI
Өгөгдөлийн хурд	HD/SD-SDI 143M, 177M, 270M, 360M, 540M, 1483.5M, 1485Mbps, or DVB-ASI
Тохируулга	Дамжуулагч болон хүлээн авагчийн цагийн тохиргоо тохируулах функцтэй байх.
Хяналт	Дамжуулагч болон хүлээн авагчийн тэжээлийн болон шилэнгийн сигналын LED гэрэлтэй байх.
Тэжээл	Хос сэлгэн залгах цахилгааны оролттой байх
Хэмжээ	19 inch 1RU box

Телевизийн студиэс өгөх дохио нь дараах стандарт, үзүүлэлтийг хангана.

ИНТЕРФЕЙС	
Дүрсийн оролт	HD болон SD форматаар SMPTE 292M (HD-SDI) гэрээнд аль форматаар дамжуулж байгааг тусгах
Дууны оролт	Embedded audio (Дүрсний сигналд нь суулгасан аудио сигнал)
ДҮРСИЙН ҮЗҮҮЛЭЛТ	
Дүрсийн харьцаа	16:9
SD нягтрал	SD-SDI 625@50i
HD нягтрал	HD-SDI, 1080@50i шахалтын стандарт нь MPEG/AVC (H.264)
ДУУНЫ ҮЗҮҮЛЭЛТ	

Дууны түвшин	Монгол Улсын “Тоон телевизийн студи. 2-р хэсэг: Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага” MNS 5592-2:2016 стандартад заасны дагуу Олон улсын EBU R128 зөвлөмжийг мөрдөх
Дууны кодлол	Стерео болон MPEG layer 2

**Тоног төхөөрөмжийн мэдээлэл:**

Холболтын техник, төхөөрөмжийн нэр, зориулалт	Телевиз талд	Дамжуулагч талд (ОСДҮЭ)
Хөрвүүлэх төхөөрөмж, (Encoder) түүний төрөл, марк, сериал дугаар	.....	Sumavision EMR 3.0
Дамжуулах (Tx) /Хүлээн авах (Rx) төхөөрөмж, түүний төрөл марк, сериал дугаар	Tx	Rx
Холбох шугамын төрөл, үзүүлэлт:	1 core fiber optic	1core fiber optic
Холболтын интерфэйс:	HD-SDI	1 plus 1 2 plus 2 4 plus 4 loop-through HD-SDI, SD-SDI 75 Ohm BNC SMPTE292M, SMPTE259M, SMPTE297M, SMPTE305M, SMPTE310M, DVB-ASI
Бусад....		

**ХАВСРАЛТ БАТАЛСАН**

“САНСАР ДИЖИТАЛ” ХХК, түүнийг  
төлөөлж техникийн захирал:

..... /Б.АМГАЛАНБАТ/  
(Гарын үсэг, тамга)

“.....” ХХК,  
түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал:


..... /...../  
(Гарын үсэг, тамга)

20... оны ..... сарын .....-ны өдрийн ..... тоот  
\_\_\_\_\_, \_\_\_\_\_-ын Холболт,  
Дамжууллын гэрээний Хавсралт 3

## ЗААГЛАХ ЦЭГИЙН БАЙРШИЛ, ЗУРАГЛАЛ


Зааглах цэг:

- Зааглах цэг нь Дамжуулагч талын сүлжээний нэг хэсэг бөгөөд зааглах цэг дэх техник, төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээг Дамжуулагч тал хариуцна.
- Сүлжээний зааглах цэгийн байршил, холболтын зураглал нь доор заасны дагуу байна.
- Талууд зааглах цэгээс 2 тийш шугамыг таслан хэмжилт, шалгалт хийх техникийн боломж, нөхцөлийг хангасан байна.





## ХОЛБОЛТЫН ЗУРАГ



## ХАВСРАЛТ БАТАЛСАН:

“САНСАР ДИЖИТАЛ” ХХК, түүнийг  
төлөөлж техникийн захирал:

..... /Б.АМГАЛАНБАТ/

(Гарын үсэг, тамга)

“.....” ХХК,  
түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал:

..... /...../

(Гарын үсэг, тамга)

20... оны ..... сарын .....-ны өдрийн ..... тоот  
 \_\_\_\_\_, \_\_\_\_\_-ын Холболт,  
 Дамжууллын гэрээний Хавсралт 4

**ХАРИЛЦАН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ АЛБАН ТУШААЛТАН**

**Дамжуулагч тал**

№	Чиглэл	Нэр	Албан тушаал	Утас	И-мэйл
1	Техникийн холбогдолтой асуудал гарсан үед:	Б. Түмэнбат	Ахлах Инженер	88097459	<a href="mailto:Tumee_88@yahoo.com">Tumee_88@yahoo.com</a>
2	ТВ-ийн хөтөлбөртэй холбоотой өөрчлөлт гарсан үед:	Ч. Ихзаяа	Инженер	99885052	<a href="mailto:ikhzayachinbat@gmail.com">ikhzayachinbat@gmail.com</a>
3	Санхүүгийн холбогдолтой асуудал гарсан үед:	Д. Ганцэцэг	Санхүүгийн захирал	99046765	<a href="mailto:ganaa_djt@yahoo.com">ganaa_djt@yahoo.com</a>
4	Маркетингийн холбогдолтой асуудал гарсан үед:	Э.Одончимэ г	Менежер	99901351	<a href="mailto:odgo0328@gmail.com">odgo0328@gmail.com</a>

**Телевизийн тал**

№	Чиглэл	Нэр	Албан тушаал	Утас	И-мэйл
1	Техникийн холбогдолтой асуудал гарсан үед:				
2	ТВ-ийн хөтөлбөртэй холбоотой өөрчлөлт гарсан үед:				
3	Санхүүгийн холбогдолтой асуудал гарсан үед:				
4	Маркетингийн холбогдолтой асуудал гарсан үед:				

**ХАВСРАЛТ БАТАЛСАН:**

“САНСАР ДИЖИТАЛ” ХХК, түүнийг  
 төлөөлж техникийн захирал:

..... /Б.АМГАЛАНБАТ/

(Гарын үсэг, тамга)

“.....” ХХК, түүнийг  
 төлөөлж гүйцэтгэх захирал:

..... /...../

(Гарын үсэг, тамга)

20... оны ..... сарын .....-ны өдрийн ..... тоот  
\_\_\_\_\_, \_\_\_\_\_-ын Холболт,  
Дамжууллын гэрээний Хавсралт 5

### ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Төлбөрийн задаргаа	Үндэслэл, тайлбар	Төлбөрийн хэмжээ
1			
2			
3			
4			
5			

### ХАВСРАЛТ БАТАЛСАН:

“САНСАР ДИЖИТАЛ” ХХК, түүнийг  
төлөөлж техникийн захирал:

..... /Б.АМГАЛАНБАТ/

(Гарын үсэг, тамга)

“.....” ХХК,  
түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал:

..... /...../

(Гарын үсэг, тамга)

20... оны ..... сарын .....-ны өдрийн ..... тоот  
\_\_\_\_\_, \_\_\_\_\_-ын Холболт,  
Дамжууллын гэрээний Хавсралт 6

ТЕЛЕВИЗИЙН ХӨТӨЛБӨР ИРҮҮЛЭХ ФОРМАТ

“ТВ нэр” Телевизийн 01-рсарын 06– ны Даваа гарагийн хөтөлбөр

Эхлэх цаг	Дуусах цаг	Нэвтрүүлгийн нэр
08:00	08:05	“Сүлд” телевиз өглөөний эхлэл
08:05	08:30	"Нар тоссон аялгуу"
08:30	09:00	"Өөрчлөлтийг өнөөдрөөс" фитнес нэвтрүүлэг
09:00	10:00	"Цаг үе" мэдээллийн хөтөлбөр/тойм/
10:00	11:00	"Гэнэн бүсгүйн инээмсэглэл" ОАК /8-р анги/
11:00	11:20	"Би уран бүтээлч" нэвтрүүлэг
11:20	13:00	"Тунгалаг тамир" МУСК /1-р анги/
13:00	14:00	"Аялгуут соёл" шууд нэвтрүүлэг
14:00	14:10	"Сүлд" телевиз энэ 7 хоногт
14:10	15:00	Баримтат кино
15:00	15:30	"Цаг үе" мэдээллийн хөтөлбөр
15:30	17:00	Арвайхээр хотын 290 жил "Арвагар хээр-2017" хангайн бүсийн зуны уралдаан /Азарга, Их нас, Соёолон/
17:00	17:30	"Цаг үе" мэдээллийн хөтөлбөр
17:30	17:50	"Бидний бүтээл" хүүхдийн нэвтрүүлэг
17:50	18:00	"Сүлд" телевиз энэ 7 хоногт
18:00	19:00	"Монгол нүнжиг" гэрээт нэвтрүүлэг/шууд/
19:00	20:00	"Миний нутаг" нэвтрүүлэг Булган аймаг Хутаг-Өндөр сум
20:00	20:10	"Өв соёл" нэвтрүүлэг Занабазарын музей
20:10	21:00	"Сүлд үү, Тоо юу?" /5-1/
21:00	21:30	"Цаг үе" мэдээллийн хөтөлбөр
21:30	22:30	"Мориор Амилсан Монгол заяа" нэвтрүүлэг МУТМУ Д.Мөнхбат
22:30	23:00	"Өнөөдрийн зочин" ярилцлага
23:00	00:00	"Гэнэн бүсгүйн инээмсэглэл" ОАК /9-р анги/
00:00	00:30	"Цаг үе" мэдээллийн хөтөлбөр
00:30	01:00	Амрах агшин
01:00	08:00	Эфир завсарласан